


Редакцийн хараат бус байдал

М.Батсуурь
Хуульч

Агуулга

- Удиртгал
- Редакцийн хараат бус байдлын агуулга
- Монгол Улс дахь эрх зүйн зохицуулалт ба асуудал
- Бусад улсын туршлага
- Санал, зөвлөмж

Удиртгал



**Иргэдийн мэдэх эрх –
Редакцийн хараат бус байдал**

Редакцийн хараат бус байдлын агуулга



Редакцийн хараат бус байдлын

Хэвлэл
мэдээллийн
хэрэгслийн
өмчлөл

- Олон нийтийн
- Хувийн (арилжааны)

Хэвлэл мэдээллийн
хэрэгслийн төрөл

- Радио, телевиз
- Хэвлэл

Дотоод хяналт

- Сэтгүүлч бүрт редакцийн хараат бус байдал хамаарах
- Ерөнхий редактор хянах эрх (Editorial integrity)

Монгол улс дахь эрх зүйн зохицуулалт ба асуудал

- Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16, 17
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, 1998 он
- Олон нийтийн радио телевизийн тухай хууль, 2002 он
- Монгол Улсын эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйл
 - Монгол улсын Дээд шүүх 2007 оны 12 дугаар сарын 21-ны өдөр 51 тоот тогтоол

Монгол улс дахь эрх зүйн зохицуулалт ба асуудал

- Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 5 дугаар зүйл:

“Олон нийтийн радио, телевизийн сурвалжлагч, **редакци** Үндсэн хууль болон энэ хуулийн үзэл санаанд нийцсэн нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгоход нь **аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, олон нийтийн радио, телевизийн удирдлага хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно**”

Монгол улс дахь эрх зүйн зохицуулалт ба асуудал

- Редакцийн хараат бус байдлыг хангасан эрх зүйн зохицуулалт хангалтгүй
- Сэтгүүлчдийн редакцийн хараат бус байдлын талаар ойлголт хангалтгүй
- Хэвлэл мэдээллийн байгууллагад эдийн засгийн ашиг сонирхол бүхий мэдээлэл болон сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд суурилсан мэдээлэл хоёрыг хатуу зааглах соёл төлөвшөөгүй байна
- Монгол улсад хэтэрхий олон телевиз үйл ажиллагаа явуулж байгаа учраас санхүүжилт хомсдож, санхүүжилтийн хойноос хэт хөөцөлдсөн нь эргээд сэтгүүлчийн редакцийн болон санхүүгийн хараат бус байдалд нөлөөлж байна.
 - 2010 оны эхний хагас жилд улсын хэмжээгээр 383 хэвлэл мэдээллийн хэрэгсэл байна. Үүнээс 69 сонин, 50 телевиз, 63 радио, кабелийн 16 телевиз



Бусад улсын туршлага

- Швейцар
- Герман
- Португали
- Норвеги
- Исланд
- Швед
- ОХУ
- Македони



Бусад улсын туршлага

- Хэвлэлийн эрх чөлөө харьцангуй хөгжсөн улсуудын эрх зүйн зохицуулалтуудыг аваад үзэхэд хэвлэл мэдээллийн эрх чөлөө, сэтгүүлчийн хараат бус байдал, төр, түүний байгууллагаас ангид, хараат бус байх тухай асуудлыг хуульчилсан боловч хэвлэл мэдээллийн байгууллагын өмчлөгч, эздээс хараат бус байх тухай шууд тусгайлан зохицуулсан хэм хэмжээ байхгүй.
 - Ёс зүйн дүрэм
 - Редакцийн дүрэм

Португали улсын Радио телевикийн тухай хууль “бүх радио, телевизийн байгууллага нь сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, зарчим, зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл, эрх, үүргийг тусгасан Редакцийн дүрэмтэй байна”



Бусад улсын туршлага

- Шведийн Хэвлэлийн эрх чөлөөний хуулийн 5 дугаар бүлгийн 3 дугаар зүйл

“Тогтмол хэвлэлийн хариуцлагатай эрхлэгчийг хэвлэлийн эзэн томилно.

Хариуцлагатай эрхлэгчийн үйл ажиллагааны хүрээнд тогтмол хэвлэлийн хэвлэлтийг хариуцан хангах, түүний хүслийн эсрэг ямар ч зүйл хэвлэгдэхгүй байхаар агуулгыг тогтоон тодорхойлох эрх багтана.

Хариуцлагатай эрхлэгчийн эдгээр эрхийг хязгаарлах ямарваа хязгаарлалт нь хууль бус ба хүчингүй байна”



Бусад улсын туршлага

- Ардчилсан шилжилтийн явц өрнөж байгаа улс орнуудад ОХУ, Македон зэргийг аваад үзэхэд харин хэвлэлийн эрх чөлөө харьцангуй өндөр хөгжсөн улсуудаас ялгаатай буюу сэтгүүлчийн редакцийн хараат бус байдлыг тусгайлан зохицуулахыг оролдсон байна.
- ОХУ-ын Нийтийн мэдээлийн хэрэгслийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт ***“Үүсгэн байгуулагч нь энэ хууль, хяналтын албанаас гаргасан дүрэм, гэрээнд зааснаас бусад байдлаар мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд оролцохыг хориглоно”***

Бусад улсын туршлага

-
- ОХУ-ын Нийтийн мэдээлийн хэрэгслийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 10 дахь хэсэг:
 - *“өөрийн итгэл, үнэмшилд нийцэхгүй мэдээ, мэдээллийг өөрийн нэрээр гаргахаас татгалзах”*,
- ОХУ-ын Нийтийн мэдээлийн хэрэгслийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн мөн 11 дэх хэсэг:
 - *“өөрийн бэлтгэсэн мэдээ, мэдээлэлд ямар нэгэн байдлаар засвар орсон, бүлэг, хэсгийн хассан, хориглсон бол өөрийн нэрээр гаргахаас татгалзах эрхтэй”*
- Македони Радио, телевизийн тухай хуулийн 59 дүгээр зүйл:
“аливаа программ, нэвтрүүлгийг ивээн тэтгэгч нь программ, нэвтрүүлгийн утга, үргэлжлэх хугацаанд нөлөөлөх замаар редакцийн бие даасан, хараат бус байдал болон хариуцлагад нөлөөлөхгүй”.



Бусад улсын туршлага

- Сэтгүүлчийн редакцийн хараат бус байдал нь өмчлөлийн төрлөөс ялгаатай эсэхийг тандах зорилгоор зарим телевизийн хуулийг авч үзэхэд Радио телевиз ба хэвлэн нийтэлдэг байгууллагын сэтгүүлчийн редакцийн хараат бус байдалд ялгаа төдийлөн анзаарагдсангүй.
- Ихэнх улс орон хэвлэл мэдээлэл, сэтгүүлч нийгмийн хооронд үүсэх харилцааг тусгайсан хууль тогтоомжоор зохицуулахаас гадна сэтгүүлч, хэвлэл мэдээллийн асуудал эрхэлсэн төрийн болон төрийн бус байгууллага байгуулан улмаар “сэтгүүлчийн ёс зүйн дүрэм” гэх баримт бичгийг батлан хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулж байна.



Санал, зӨвлӨмж

- Хэвлэл мэдээллийн хэрэгслийг шууд болон шууд бус байдлаар эзэмшдэг эздийн талаарх мэдээ баримтыг олон нийтэд нээлттэй байлгах, энэ талаарх зохицуулалтыг хууль тогтоомжид тусгах
- Сэтгүүлчийн болоод редакцийн бие даасан, хараат бус байдлыг хангах зохицуулалтын хууль тогтоомжид тусгайлан оруулах
- Хэвлэл мэдээллийн хууль тогтоомжид хэвлэл мэдээллийн байгууллагын дотоод дүрэм, ёс зүйн дүрмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэд өөрсдийн эдийн засгийн болон улс төрийн ашиг сонирхлын тусын тулд хэвлэл мэдээллийг зүй бусаар ашиглахаас сэргийлэх, тийм үйлдлийг хориглох зарчим, арга хэрэгслийг тусгах

Санал, зөвлөмж

- Хэвлэл мэдээллийн байгууллагын редакцийн дүрэм, сэтгүүлчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих Хэвлэлийн консул, бие даасан омбудсменыг бий болгож, эрх зүйн статус, эдлэх эрх, хүлээх үүрэг, маргаан хянан шийдвэрлэх журам зэргээр үйл ажиллагааг нь зохицуулах
- нийтийн өмч болох долгион ашигладаг радио, телевизийн үйл ажиллагааны зөвшөөрлийг хавтгайруулан олгох явдлаас татгалзах

- 
- Анхаарал тавьсанд баярлалаа